

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалт, үнэлгээний газар



Хяналт шалгалтын
ажлын сарын
мэдээ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

(2022 оны 03.16-04.30)

Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

НЭГ. ТҮР ХОРОО

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

- 2.1.1. Үйл ажиллагаа үргэлжилсэн ажлын хэсэг
- 2.1.2. Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

- 2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилсэн ажлын хэсэг
- 2.2.2. Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг

2.3. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

- 3.1. АСУУЛГА
- 3.2. АСУУЛГЫН ХАРИУ
- 3.3. АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР
- 3.4. АСУУЛТ
- 3.5. АСУУЛТЫН ХАРИУ
- 3.5. АСУУЛТЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

- 4.1. ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ
- 4.2. БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР СОНССОН МЭДЭЭЛЭЛ

ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 5.1. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



Хүснэгт 1. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан түр хороо

Д/д	Түр хороо байгуулсан тогтоол	Түр хорооны бүрэлдэхүүн
1.	2020.10.29 №31 Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай /КОВИД-19/	<p>Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр</p> <p>Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Х.Болорчулуун - БОХХААБХ, Ж.Мөнхбат - БСШУСБХ, Б.Бат-Эрдэнэ - ЁЗСХБХ, Н.Учрал - ИЦББХ, М.Оюунчимэг - НББХ, Л.Энх-Амгалан - ТББХ, Б.Жавхлан - ТБХ, Б.Чойжилсүрэн - ҮББХ, С.Бямбацогт - ХЗБХ, Ж.Ганбаатар - ЭЗБХ-ны дарга нар болон Б.Бейсен - УИХ дахь АН-ын төлөөлөл, С.Ганбаатар - УИХ дахь "Та бидний эвсэл"-ийн төлөөлөл, Т.Доржханд - УИХ дахь "Зөв хүн электорат эвсэл"-ийн төлөөлөл, Н.Алтанхуяг - Бие даагч</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох, Х.Хэрлэн</p>
2.	2022.04.15 №14 Хянан шалгах түр хороо байгуулах тухай /Хөгжлийн банкны асуудлаарх/	<p>Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар</p> <p>Түр хорооны гишүүд: Олонхыг төлөөлөн: УИХ-ын гишүүн Д.Батлут, Э.Батшугар, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхцэцэг, Б.Энхбаяр</p> <p>Цөөнхийг төлөөлөн: Ж.Батсуурь, Н.Ганибал, Т.Доржханд</p> <p>ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ХШХ-ийн дарга Ж.Лхагвасүрэн, референт Ц.Рэнцэнтогтох</p>

2022 оны 3 дугаар сарын 16-31, 4 дүгээр сард ажилласан Улсын Их Хурлын тогтоолоор тодорхой асуудлыг шалган судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагааны мэдээлэл:



1. Улсын Их Хурлын 2020 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагаа:**

- Түр хорооноос өгсөн чиглэлийн дагуу Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, авч буй арга хэмжээний талаарх мэдээллийг тогтмол авч, холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 2022.03.15-ны өдрийн хуралдаанаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2021 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар болон тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл, мөн Эрүүл мэндийн яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, вакцинжуулалтын талаарх мэдээллийг тус тус сонссон.



2. Улсын Их Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгах үүрэг бүхий түр хорооны үйл ажиллагаа:**

- 2022.04.20-ны өдрийн түр хорооны анхны хуралдаанаар УИХ-ын гишүүн, түр хорооны гишүүн Ж.Сүхбаатарыг түр хорооны даргаар сонгов.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт


2022 оны 3 дугаар сарын 16-31, 4 дүгээр сард хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэгтэй байгуулагдсан нийт 23 ажлын хэсэг (давхардсан тоогоор Улсын Их Хурлын 112 гишүүн ажилласан) байна.

Үүнээс:

- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан 4;
- Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 18;
- Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1 ажлын хэсэг байна.

График 1. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2020 оны намрын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан (8)
- 2021 оны хаврын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан (5)
- 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (8)
- 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (2)



Хүснэгт 2. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

Хугацаа	УИХ-ын даргын захирамж	Байнгын хорооны тогтоол	Дэд хорооны тогтоол
2020 оны намрын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан	2	5	1
2021 оны хаврын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд байгуулагдсан	2	3	-
2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	8	-
2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	2	-
Нийт - 23	4	18	1



ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	2021.03.02 №16 ЗАХИРАМЖ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
2.	2021.03.11 №18 ЗАХИРАМЖ Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Х.Болорчулуун, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам, О.Цогтгэрэл ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: референт Д.Гэрэлт-Од
3.	2021.03.18 №21 ЗАХИРАМЖ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмших, ашиглахтай холбоотой газрын харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
4.	2022.01.31 №20 ЗАХИРАМЖ Монгол Улсын Хөгжлийн банкаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, С.Чинзориг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Газрын дарга С.Янжинхорлоо, ахлах зөвлөх Ш.Батцэнгэл, референт Ч.Сарантуяа, Г.Оюун-Эрдэнэ

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1.1. Үйл ажиллагаа үргэлжилсэн ажлын хэсэг



2022 оны 3 дугаар сарын 16-31, 4 дүгээр сард ажилласан Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн үйл ажиллагааны мэдээлэл:

1. Улсын Их Хурлын даргын 2021 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд **Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг**”-ийн үйл ажиллагаа:

- ЭМЯ, ХӨСҮТ, УОК болон УОК-ын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлөөс өдөр бүр ажлын хэсэгт мэдээлэл өгч байна.
- 2022.03.29-ний өдрийн байдлаар /КОВИД-19/-ын эсрэг вакцины хамралт:

зорилтот бүлгийн:

- I тунгийн хамралт **96.4 хувь**;
- II тунгийн хамралт **92.2 хувь**;
- III тунгийн хамралт **53.0 хувь** байна.

нийт хүн амын:

- I тунгийн хамралт **69.8 хувь**;
- II тунгийн хамралт **66.8 хувь**;
- III тунгийн хамралт **31.7 хувь** байна.

Өссөн дүнгээр **I тунд** 6,420 жирэмсэн эмэгтэй, 7,999 хөхүүл эмэгтэй, 12-15 насны 165,573 хүүхэд, 16-17 насны 77,959 хүүхэд хамрагдсан бол **III тунд** 1,032,361 хүн, **IV тунд** 114,632 хүн хамрагдсан байна.

- 2022.04.27-ны өдрийн байдлаар КОВИД-19-ын эсрэг вакцины хамралт:

зорилтот бүлгийн:

- I тунгийн хамралт **96.4 хувь**;
- II тунгийн хамралт **92.3 хувь**;
- III тунгийн хамралт **53.1 хувь** байна.

нийт хүн амын:

- I тунгийн хамралт **69.9 хувь**;
- II тунгийн хамралт **66.9 хувь**;
- III тунгийн хамралт **31.9 хувь** байна.

Өссөн дүнгээр **I тунд** 6,425 жирэмсэн эмэгтэй, 8,008 хөхүүл эмэгтэй, 12-15 насны 162,052 хүүхэд, 16-17 насны 78,258 хүүхэд хамрагдсан бол **III тунд** 1,039,267 хүн, **IV тунд** 123,504 хүн хамрагдсан байна.

2.1.2. Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг



1. Улсын Их Хурлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар байгуулагдсан **Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дүгнэлт Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**

- Ажлын хэсэг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу Хөгжлийн банкны нөхцөл байдалтай танилцаж, банкны удирдлагуудтай уулзан удирдамжийн хүрээнд шаардлагатай тодруулга, мэдээлэл авч ажилласан.
- 2022.03.16-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанд ажлын дэд хэсэг явцын тайлангаа танилцуулсан. Мөн газар дээрх шалгалт хийсэн багуудын тайлан, илтгэлийг сонсож, цаашид анхаарах зүйлсийн талаар ажлын дэд хэсэгт чиглэл өгсөн.
- 2022.03.22, 23-ны өдрүүдэд 61 зээлдэгч тус бүртэй ярилцлага зохион байгуулсан.
- Ажлын хэсэг Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын үнэлгээчидтэй хамтран ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн нийт ажлын талаар нэгтгэн хэлэлцсэн.
- 2022.03.29-ний өдөр зохион байгуулсан Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонголд ажлын хэсэг тайлангаа танилцуулснаар **ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.**

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН НИЙТ АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо		
1	2021.12.24 №03 ТОГТООЛ Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсагбулагийн сав газарт ажиллах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Н.Наранбаатар, Ц.Сэргэлэн, Б.Энх-Амгалан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар, референт С.Төрмөнх
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо		
2	2021.11.16 №12 ТОГТООЛ "Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Ганболд, Н.Ганибал, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
3	2021.11.16 №13 ТОГТООЛ "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Батжаргал Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Т.Аубакир, Б.Бейсен, Г.Мөнхцэцэг, Б.Саранчимэг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
4	2022.04.13 №05 ТОГТООЛ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт болон ус ашиглалтын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Саранчимэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Ганболд, Н.Наранбаатар, Ц.Туваан, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо		
5	2021.01.13 №01 ТОГТООЛ Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт "төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ч.Ундрам, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
6	2021.01.17 №03 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр баталсан Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг "Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна" гэж заасны хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ч.Ундрам Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн П.Анужин, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Ж.Чинбүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан		
7	2021.05.25 №06/03 ТОГТООЛ “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц байдалтай танилцан, шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Ганхуяг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн А.Адьяасүрэн, Г.Амартүвшин, П.Анужин, Г.Мөнхцэцэг, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Референт С.Төрмөнх
Нийгмийн бодлогын байнгын хороо		
8	2022.01.04 №01 ТОГТООЛ Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, Ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Жаргалмаа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Д.Батлут, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Туваан, Ч.Ундрам, С.Чинзориг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ц.Рэнцэнтогтох
9	2022.04.12 №09 ТОГТООЛ Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Ганбаатар, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
Төрийн байгуулалтын байнгын хороо		
10	2022.01.17 №04 ТОГТООЛ Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Г.Ганболд, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх Б.Нандингэрэл, референт Ц.Отгонбаатар
Төсвийн байнгын хороо		
11	2020.11.04 №05 ТОГТООЛ Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Булгантуяа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд
12	2020.12.30 №07 ТОГТООЛ Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын биелэлтэд хяналт тавих зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
13	2021.01.20 №01 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын (Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай) хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од
Хууль зүйн байнгын хороо		
14	2020.12.24 №09 ТОГТООЛ Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар
15	2021.03.15 №07 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
16	2021.03.15 №08 ТОГТООЛ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага тооцох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Энх-Амгалан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
Эдийн засгийн байнгын хороо		
17	2021.10.27 №13 ТОГТООЛ "Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Баттөмөр, Ч.Ундрэм ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ХШХ-ийн дарга Ж.Лхагвасүрэн, зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Д.Отгонбаатар, С.Төрмөнх
18	2021.11.30 №17 ТОГТООЛ Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан "Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгаж, арилжааны банкуудад байршиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах талаар санал, санал дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Д.Батлут, Х.Булгантуяа, Т.Доржханд ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ХШХ-ийн дарга Ж.Лхагвасүрэн, зөвлөх М.Солонго, референт Ч.Сарантуяа

2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилсэн ажлын хэсэг

2022 оны 3 дугаар сарын 16-31, 4 дүгээр сард ажилласан Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны мэдээлэл:

1. Төсвийн байнгын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан **Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн** үйл ажиллагаа:

- 2022.03.23-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу Дэлхийн банкнаас 2019 онд хийсэн судалгаанд үндэслэн Монгол Улсын төсөвт жил бүр хийгддэг шинжилгээний шинэчилсэн мэдээллийг Сангийн яамнаас авч ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан.
- Мөн ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийн төслийг ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан.



2. Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн** үйл ажиллагаа:

- 2022.03.30-ны өдрийн ХЗБХ-ны хуралдаанаар Гадаад харилцааны яам болон ХЗДХЯ-наас хариуцан хэрэгжилтийг тайлагнадаг олон улсын гэрээ, конвенцийн талаар ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил танилцуулсан.
- Тус хуралдаанаас олон талт олон улсын 30 гэрээний хэрэгжилтийг Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээнд ХЗБХ-той хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгов.



3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт “төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн** үйл ажиллагаа:

- 2022.03.28-ны өдрийн БСШУСБХ-ны хуралдаанаар ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр Засгийн газарт чиглэл өгсөн тус Байнгын хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг БШУЯ-ны ТНБД, ажлын дэд хэсгийн ахлагч Л.Цэдэвсүрэн танилцуулав.
- 2022.04.09-ний өдөр ажлын дэд хэсэг хуралдаж, үйл ажиллагааны явцын талаар хэлэлцсэн.



4. Эдийн засгийн байнгын хорооны 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан **Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсгийн** үйл ажиллагаа:

- 2022.04.12-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлын явцын талаар ЗТХЯ, МХЕГ болон төслийн зөвлөх компанийн мэдээллийг сонссон. Мэдээлэлтэй холбогдуулан үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг холбогдох газруудад үүрэг өгсөн.
- 2022.04.19-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Гадаадын иргэн, харьяатын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанд ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл ирүүлэхийг хүссэн албан бичгийг тус тус хүргүүлсэн.

- 2022.04.22-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яам болон Сэлэнгэ аймгийн Баянгол, Төв аймгийн Борнуур, Баянчандмань, Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлсэн.
- 2022.04.26-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн яам, Тээврийн цагдаагийн албанаас Дархан-Улаанбаатар чиглэлийн автозамын нөхцөл байдал, хөдөлгөөний аюулгүй байдлын талаар мэдээлэл хийсэн.



5. Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан **Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**

- 2022.03.21-24-ний өдрүүдэд ажлын хэсгийн гишүүд Баян-Өлгий аймгийн Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагаатай танилцаж, цаашид хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах талаар хуулийн хэрэгжилтийг хангуулах, Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын асуудал, бэлчээрийн даац, хадлангийн асуудлаар төрийн захиргааны байгууллагын удирдлагуудтай санал солилцсон.
- 2022.03.25, 28-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагаатай танилцсан тухай болон Баян-Өлгий аймагт ажилласан талаарх мэдээллийг сонссон.

Мөн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар болон шинээр улсын тусгай хамгаалалтад авах газрын болон хамгаалалтын захиргааны асуудал, цаашид хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, тус бүс нутагт үүссэн суурьшлийн бүсийг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг хэлэлцсэн.



- 2022.04.08-10-ны өдрүүдэд ажлын хэсгийн гишүүд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудад ажиллалаа. Орон нутагт ажиллахдаа Говьсүмбэр аймгийн Чойрын богдуулын байгалийн нөөц газар, Дорноговь аймгийн Их Нарт байгалийн цогцолборт газар, Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл, Хөнжлийн уулын талаарх танилцуулга мэдээллийг сонсож, тусгай хамгаалалтад авах газруудын ашиглалтын нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан.
- 2022.04.20-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн солбицолын цэгийг тогтоох, тус бүс дэх тусгай зөвшөөрөл, уламжлалт мал аж ахуй эрхлэх асуудал, хуулиар зөвшөөрөгдсөн ажил үйлчилгээ эрхлэх, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуультай уялдуулах, норм, дүрэм, стандартыг шинэчлэх зэрэг асуудлыг хэлэлцэв.
- 2022.04.24-ний өдөр ажлын хэсэг Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянхангай сумдын нутгийн заагт орших Хустайн байгалийн цогцолборт газрын үйл ажиллагаатай танилцаж, “Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн шинэчлэл, тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдвээр БОАЖЯ-ны мэдээллийг сонсож, санал солилцов.

6. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан **Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсагбулагийн сав газарт ажиллах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**

- Ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл ирүүлэхийг хүссэн 2022.03.22-ны өдрийн албан бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Үндэсний аудитын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт тус тус хүргүүлж, ирүүлсэн мэдээлэлтэй холбогдуулан Байнгын хороонд танилцуулах танилцуулгыг бэлтгэж байна.

7. Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, Ахмад настны асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**



- 2022.03.16-ны өдөр ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд “Ахмад настны нийгмийн халамж, төлбөрт үйлчилгээг нэвтрүүлэх боломж, шийдэл сэдэвт хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулсан.
- 2022.03.23-ны өдөр ажлын хэсгийн гишүүд болон ХНХЯ, ЭМЯ, Сангийн яам, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын холбогдох албан тушаалтнууд “Геронтологийн үндэсний төв”, СХД-ийн “Наян зургаа дөрвөн зуу” ТББ ахмад настанд өдрийн үйлчилгээ үзүүлэхээр гэрээлсэн байгууллагын үйл ажиллагаатай танилцсан.
- 2022.03.28-ны өдөр Геронтологийн төвийн барилга, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын асуудлаар захиалагч Эрүүл мэндийн яам, Барилгын хөгжлийн төв, гүйцэтгэгч компани “Арвис интернейшнл” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, барилгыг үргэлжлүүлэхэд шаардагдах дүгнэлт, шинжилгээ хийж ирүүлэхийг Эрүүл мэндийн яам, Барилгын хөгжлийн төвд үүрэг болгосон.
- 2022.04.26-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар ажлын хэсгийн явцын тайланг хэлэлцэж, тайланг Байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

8. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан **Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 5 дугаар сарын 03-ны өдөр баталсан Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасны хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**



- 2022.03.28-ны өдрийн БСШУСБХ-ны хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийг хэлэлцүүлэн батлуулсан.
- 2022.04.22-ны өдөр ажлын хэсэг Хан-Уул дүүргийн 75 дугаар сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцав. 75 дугаар сургууль нь Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан ба олон улсын стандартад нийцсэн, хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах тэгш боломжит сургалтын орчинг бүрдүүлсэн төрийн өмчийн анхны сургууль юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийг БНХАУ-ын буцалтгүй тусламжаар байгуулсан ба 0-18 хүртэлх насны бүх төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт оношлох, сэргээн засах болон сэтгэл зүй, ортопед, туслах бусад хэрэгслүүдийг өөрсдөө үйлдвэрлэн тусламж үйлчилгээг үзүүлэх зэрэг үйлчилгээг үнэ төлбөргүйгээр 1 сараас 1 жилийн хугацаанд үзүүлдэг байна.

9. Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**

- 2022.04.27-ны өдөр Соёлын яамнаас зохион байгуулсан “Соёлын салбар дахь хүүхдийн эрхийн хэрэгжилт” хэлэлцүүлэгт оролцсон. Тус хэлэлцүүлэг нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн ээлжит үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан байна.



10. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан **Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт болон ус ашиглалтын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**

- 2022.04.19-ний өдрийн БОХХААБХ-ны 06 дугаар тогтоолоор ажлын хэсгийн удирдамжийг баталсан.
- 2022.04.26-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар ажлын хэсгийн төлөвлөгөө, ажиллах зарчмын талаар хэлэлцэж, ажлын хэсгийн ахлагчаас төлөвлөгөө боловсруулан танилцуулах үүргийг ажлын дэд хэсгийн гишүүдэд өгсөн.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.2.2. Үйл ажиллагаа дуусгавар болсон ажлын хэсэг



1. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулагдсан **Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**

- Ажлын хэсэг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, ХХААХҮЯ-ны мэдээллийг сонссон. Мөн ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Биокомбинат, Мал эмнэлгийн холбоо болон Хэнтий, Говьсүмбэр аймгийн Хөдөө аж ахуйн газар болон тус аймгийн малын эмч, малчдын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Ажлын хэсгийн хуралдаанаар:
 - Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт;
 - Мэргэжлийн хяналт болон Мал эмнэлгийн байгууллагын чиг үүрэг;
 - Мал эмнэлгийн үйл ажиллагаа;
 - Бүх шатны Засаг даргын эрх, үүрэг;
 - Отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн, түүнтэй холбоотой хариуцлагын тогтолцооны асуудал;
 - Мал эмнэлгийн ерөнхий газрын бүтэц, орон тоо;
 - Мал эмнэлгийн Мэргэжлийн зөвлөлөөс гаргасан журам, шийдвэр, зөвлөмж;
 - Эмийн зөвлөлийн талаар болон вакцинжуулалт, халдваргүйтгэл болон түүний санхүүжилт, хорио цээрийн зэрэг асуудал;
 - холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах болон тогтоолын төсөлд санал авах, цаашид авах арга хэмжээний талаарх асуудлыг хэлэлцсэн байна.
- 2022.04.13-ны өдрийн БОХХААБХ-ны хуралдаанд ажлын хэсэг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн талаарх санал, дүгнэлтээ танилцуулан "Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлж, Байнгын хорооны 2022 оны 04 дүгээр тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөнөөр ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.



2. Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа:**

- Ажлын хэсгийн гишүүд батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу МҮОНРТ-ийн үйл ажиллагаатай танилцаж, МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл, удирдлага, албан хаагчидтай уулзалт хийсэн. Удирдлагуудтай хийсэн хуралдааны үеэр МҮОНРТ-д үүсээд буй нөхцөл байдлын талаарх мэдээллийг сонсож, МҮОНРТ-ын Үндэсний зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагад хугацаатай үүрэг, даалгавар өгч, хариу мэдээллийг сонссон.
- 2022.04.20-ны өдрийн ТББХ-ны хуралдаанд ажлын хэсэг санал, дүгнэлтээ танилцуулж, Засгийн газар болон МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд Байнгын хорооны тогтоолоор чиглэл өгснөөр ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.

2.3. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 5. Улсын Их Хурлын дэд хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо		
1	2020.10.26 №01 ТОГТООЛ Уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Саранчимэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Т.Аубакир, Г.Ганболд, Г.Дамдинням, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох

2022 оны 3 дугаар сарын 16-31, 4 дүгээр сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад хандан 10 асуулга, 5 асуулт тавьж, холбогдох албан тушаалтнаас 5 асуулга, 5 асуултын хариуг ирүүлсэн байна.

3.1. АСУУЛГА



- 2022.03.17-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Аюурсайханаас Монголбанкны Ерөнхийлөгчид хандаж “Төрийн банк” ХХК-ийн 2012-2022 оны үйл ажиллагааны талаар тавьсан **06 дугаар асуулга**;

<http://parliament.mn/files/148625>

- 2022.03.17-ны өдөр УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар тавьсан **07 дугаар асуулга**;



- 2022.03.31-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Энхболдоос Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” тавьсан **10 дугаар асуулга**;

<http://parliament.mn/n/nh3yn>

- 2022.04.04-ний өдөр УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандаж “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар” тавьсан **11 дүгээр асуулга**;



- 2022.04.04-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Алтанхуягаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Төрийн өмчийн талаар авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний тухай” тавьсан **14 дүгээр асуулга**;

<http://parliament.mn/n/je4yn>



- 2022.04.13-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Шадар сайдад хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан **16 дугаар асуулга**;

<http://parliament.mn/n/jo4yn>



- 2022.04.14-ний өдөр УИХ-ын гишүүн Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайдад хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар” тавьсан **17 дугаар асуулга**;

<http://parliament.mn/n/hy4yn>



- 2022.04.14-ний өдөр УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашдын бодлого, зорилтын талаар” тавьсан **18 дугаар асуулга**;

<http://parliament.mn/n/cy4yn>



- 2022.04.18-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн үйл явц, үр дүнгийн талаар” тавьсан **19 дүгээр асуулга**;

<http://parliament.mn/n/we4yn>



- 2022.04.13-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Шадар сайдад хандаж “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын талаар” тавьсан **20 дугаар асуулга**;

<http://parliament.mn/n/se4yn>

3.2. АСУУЛГЫН ХАРИУ

- 2022.03.17-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Аюурсайханаас Монголбанкны Ерөнхийлөгчид хандаж “Төрийн банк” ХХК-ийн 2012-2022 оны үйл ажиллагааны талаар” тавьсан **06 дугаар асуулгын хариуг** 2022.04.15-ны өдрийн н/55 дугаар албан бичгээр;
- 2022.03.17-ны өдөр УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар” тавьсан **07 дугаар асуулгын хариуг** 2022.04.15-ны өдрийн ХЭГ/825 дугаар албан бичгээр;
- 2022.03.31-ний өдөр УИХ-ын гишүүн Н.Энхболдоос Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” тавьсан **10 дугаар асуулгын хариуг** 2022.04.15-ны өдрийн 01/1310 дугаар албан бичгээр;
- 2022.04.04-ний өдөр УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандаж “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар” тавьсан **11 дүгээр асуулгын хариуг** 2022.04.28-ны 01/1150 дугаар албан бичгээр;
- 2022.04.04-ний өдөр УИХ-ын гишүүн Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайдад хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар” тавьсан **17 дугаар асуулгын хариуг** 2022.04.28-ны 1а/1984 дүгээр албан бичгээр тус тус ирүүлсэн.

<http://parliament.mn/n/hr4yn>



3.3. АСУУЛГЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР

- 2022.03.25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын боломжийг нээх болон “Монгол мал-II” арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар” тавьсан 20 дугаар асуулгын хариуг;
- 2022.04.08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлын явц, түүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлэх бусад арга хэмжээний талаар” тавьсан 06 дугаар асуулга, УИХ-ын гишүүн Ш.Адъяагаас Эрчим хүчний сайдад хандаж “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж байгуулахтай холбоотой авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар” тавьсан 46 дугаар асуулгын хариуг тус тус хэлэлцсэн.

3.4. АСУУЛТ

- 2022.03.24-ний өдөр УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар” тавьсан **08 дугаар асуулт**;

<http://parliament.mn/n/9w4yn>



- 2022.03.25-ны өдөр УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгээс Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандаж “Гишүүний бүрэн эрхэд халдсан талаар” тавьсан **09 дүгээр асуулт**;
- 2022.04.05-ны өдөр УИХ-ын гишүүн Х.Ганхуягаас Монгол Улсын Шадар сайдад хандаж “Хилийн боомтуудын үйл ажиллагааны талаар” тавьсан **12 дугаар асуулт**;
- 2022.04.05-ны өдөр УИХ-ын гишүүн Х.Ганхуягаас Монголбанкны Ерөнхийлөгчид хандаж “Төгрөг, долларын ханш болон төлбөр тооцооны асуудалд ямар зохицуулалт хийж байгаа талаар” тавьсан **13 дугаар асуулт**;

- 2022.04.13-ны өдөр УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгээс Барилга, хот байгуулалтын сайдад хандаж “Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6, 7, 13 дугаар хороодыг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэлийн талаар” тавьсан **15 дугаар асуулт**.

<http://parliament.mn/n/jw4yn>



3.5. АСУУЛТЫН ХАРИУ



- 2022.03.07-ны өдөр УИХ-ын гишүүн С.Ганбаатараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Оюу толгойн уурхайгаас олборлосон бүтээгдэхүүний борлуулалтын талаар” тавьсан **04 дүгээр асуултын хариуг** 2022.03.21-ний өдрийн ХЭГ/558 дугаар албан бичгээр;
- 2022.03.09-ний өдөр УИХ-ын гишүүн Х.Ганхуягаас Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандаж “Нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын талаар” тавьсан **05 дугаар асуултын хариуг** 2022.03.25-ны өдрийн 1/1639 дүгээр албан бичгээр;
<http://parliament.mn/n/9r3on>
- 2022.03.24-ний өдөр УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж “Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар” тавьсан **08 дугаар асуултын хариуг** 2022.04.08-ны өдрийн 01/1100 дүгээр албан бичгээр;
<http://parliament.mn/n/9a4yn>
- 2022.03.25-ны өдөр УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгээс Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандаж “Гишүүний бүрэн эрхэд халдсан талаар” тавьсан **09 дүгээр асуултын хариуг** 2022.04.13-ны өдрийн 1/2094 дүгээр албан бичгээр;
- 2022.04.05-ны өдөр УИХ-ын гишүүн Х.Ганхуягаас Монголбанкны Ерөнхийлөгчид хандаж “Төгрөг, долларын ханш болон төлбөр тооцооны асуудалд ямар зохицуулалт хийж байгаа талаар” тавьсан **13 дугаар асуултын хариуг** 2022.04.05-ны өдрийн А-1/403 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

3.6. АСУУЛТЫН ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР

- 2022.04.27-ны өдрийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж ““Ноос, ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Байнгын хорооны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар” тавьсан 08 дугаар асуултын хариуг хэлэлцсэн.

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйл

4.1. ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

- 2022.03.18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хийх Ерөнхий сайдын мэдээллийн цагаар “Газрын шинэтгэлийн бодлого, газрын харилцааны цахим системийн талаар” Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар мэдээлэл хийв.
- 2022.04.01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хийх Ерөнхий сайдын мэдээллийн цагаар “Эрдэс баялгийн салбарын хөгжлийн бодлого, шинэчлэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон мэдээлэл хийв.

4.2. БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ

- 2022.03.15-ны өдрийн /КОВИД-19/-ын Түр хорооны хуралдаанд “Монгол Улсын Засгийн газраас 2021 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар УОК авч хэрэгжүүлсэн нөхцөл байдлын талаар” Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайхан, “ЭМЯ-наас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, нөхцөл байдлын талаар” Эрүүл мэндийн сайд С.Энхболд нар мэдээлэл хийв.
- 2022.03.28-ны өдрийн БСШУСБХ-ны хуралдаанд “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалтын хэрэгжилтийн талаар”-ийг Боловсрол, шинжлэх ухааны яамны ТНБД Л.Цэдэвсүрэн танилцуулав.
- 2022.03.30-ны өдрийн АБГББХ-ны хуралдаанд “Цөмийн энергийн комиссын үйл ажиллагааны тайлан”-г Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав танилцуулав.
- 2022.04.13-ны өдрийн БОХХААБХ-ны хуралдаанд “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ танилцуулав.
- 2022.04.19-ний өдрийн БОХХААБХ-ны хуралдаанд “Хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаар” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан танилцуулав.



5.1. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ



- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан;
- "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2021 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга;
<http://parliament.mn/n/9h4yn>
- ""Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" болон "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хоорондын уялдаа, 2021 оны хэрэгжилтийн танилцуулга"-ыг тус тус ЕНБД-ын 22.03.15-ны өдрийн ТГ-1/242 дугаар албан бичгээр ТББХ, ЭЗБХ-нд хороонд хүргүүлсэн.

Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ



Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, тайланг ЕНБД-ын 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн ТГ-01/355 дугаар албан бичгээр БОХХААБХ-нд хүргүүлсэн.

<http://www.parliament.mn/n/yw4on>

Хуульд заасан хугацаанд ирүүлсэн тайланд хийсэн шинжилгээ

- "Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийсэн талаарх танилцуулга"-ыг ЕНБД-ын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ТГ-01/382 дугаар албан бичгээр ЭЗБХ-нд хүргүүлсэн.
- "Үндэсний статистикийн хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийсэн талаарх танилцуулга"-ыг ЕНБД-ын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ТГ-01/382 дугаар албан бичгээр ЭЗБХ-нд хүргүүлсэн.
- "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийсэн талаарх танилцуулга"-ыг ЕНБД-ын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ТГ-01/380 дугаар албан бичгээр НББХ-нд хүргүүлсэн.
- "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийсэн талаарх танилцуулга"-ыг ЕНБД-ын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ТГ-01/380 дугаар албан бичгээр НББХ-нд хүргүүлсэн.
- "Төрийн аудитын байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний талаарх танилцуулга"-ыг ЕНБД-ын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ТГ-01/380 дугаар албан бичгээр НББХ-нд хүргүүлсэн.

